

Монголын дээд боловсролын салбарын статистик өөрчлөлт

Данзангийн Нарантуяа, доктор (Ph.D)
Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн
Улаанбаатар, Монгол улс, narantuyan@mas.ac.mn,
<https://orcid.org/0000-0003-4441-4910>

Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

Түлхүүр үгс

Монгол улс, дээд
боловсрол, социализм,
төгсөгчид, мэргэжил

Хураангуй: Энд БНМАУ ба Монгол улсын дээд боловсролын хөгжлийн түүхийг товч өгүүлж, их, дээд сургууль төгсөгчдийн мэргэжлийн статистик болон холбогдох баримтыг харьцуулж шинжилсэн. Судалгааны дүнгээс үзвэл, социализмын үед хүний их эмч, монгол хэл, утга зохиол, инженер, орос хэл болон тоо физик, нябо, эдийн засагч гэсэн мэргэжлээр голлон төгсдөг байсан бол орчин үед бизнес, удирдахуй, хууль эрх зүйгээр төгсөгчид нийт төгсөгчдийн 1/3-ийг эзлэх болсон байна. Мөн инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын мэргэжлийн эрэмбэ ухарч, тоо физикийн мэргэжил урлаг хүмүүнлэгт түрэгджээ. 1990 оноос өмнө манай улсын дээд боловсролын систем нь хүн амыг эрүүлжүүлэх, гэгээрүүлэхийн зэрэгцээ социалист нийгмийн мэргэжилтэн, удирдагчид бэлтгэж, ХАА, үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлтэй байсан бол өнөөгийн дээд боловсролд бизнес ба удирдахуй давамгайлж байна.

Key changes in Mongolian higher education statistics

Narantuya Danzan, Ph.D
Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia, narantuyan@mas.ac.mn,
<https://orcid.org/0000-0003-4441-4910>

Keywords

Mongolia, higher
education, socialism,
graduates, professions

© The Author(s), 2025



Abstract: This article briefly describes the history of the development of higher education in the Mongolian People's Republic and Mongolia, and examines changes in graduates's professions based on education statistics and historical documents. Results of the study show that during the socialist era the main professions and specialties of graduates were medicine, Mongolian language and literature, engineering, Russian language, mathematics, accounting and economics. In modern times, graduates in business, management, and law have taken over 1/3 of all graduates. Moreover, the ranking of art and humanities has elevated. On the contrary, physics has devalued and the high ranking of engineering, manufacturing, and construction has lowered. Prior to 1990, the higher education system was aimed at health caring and educating the population, as well as training specialists and leaders of the socialist society to develop agriculture and industry in the country. Nowadays, business and management dominate in modern higher education.

І.ОРШИЛ

1921 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн Сургуулийн танхим байгуулах тухай Ардын Засгийн газрын 11 дүгээр хурлын тогтоолд “*Олон хөвгүүд, охидын сургуулийн танхим байгуулахыг хэлэлцээд энэхүү сургуулийн танхим нээж, олон хөвгүүд, охидыг нас багад, элдэв зүйлийн бичиг заан сургаж, оюуныг судлуулан, олон түмний хэрэгт туслуулахыг хичээх нь үнэхээрийн сайн хэрэг тул эл танхим байгуулан хуралдуулж сургах хэргийг Засгийн газраас эрхэлж, нарийн чанга дүрэм хэмжээ тогтоож, Улсын хуралд үзүүлэн тогтоолгохоор хэлэлцэв*” хэмээн ардыг гэгээрүүлэх шинэ үеийн түүхийн хуудсыг бичжээ. Үүнээс хойш ард иргэдийг сургах хэрэг өргөжиж, 1940 онд Улаанбаатар хотын Багшийн сургуулийн дэргэд дунд сургуулийн багш бэлтгэх 2 жилийн хугацаатай факультет байгуулсан ба 1941 онд Нам улсын төв сургуулийг МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын шинэ хүчний дээд сургууль болгон өөрчлөн байгуулж, бүрэн биш дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх болсон нь дээд боловсролыг хөгжүүлэх анхны алхам болсон байна. Дэлхийн коммунист удирдагчдын зааснаар “Мэдлэг, техник, туршлагын янз бүрийн салаа мөчрийн мэргэжилтэн нарын удирдлагагүйгээр социализмд шилжиж болохгүй” (Ленин, 1975:262) байв. 1940 оны 12 дугаар сарын 6-нд “Улаанбаатар хотод улсын университетийг байгуулах тухай” БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарчээ. Үүний дагуу 1942 оны 10 дугаар сарын 5-нд манай улсын анхны дээд боловсролын байгууллага болох МУИС нь зоотехник, хүн эмнэлэг, сурган

хүмүүжүүлэх салбартай, 93 жинхэнэ, 57 бэлтгэл оюутантай хичээллэж эхэлсэн юм. 1946 онд МУИС анхны төгсөлтөө хийж, 35 оюутан дээд боловсролын диплом гардан авчээ (БСШУЯ, 2001: 12-13).

1966 оны хууч гэхэд анхны их сургууль маань Улсын багшийн, Хөдөө аж ахуйн, Анагаах ухааны болон Политехникийн гэсэн 4 дээд сургуулийг төрүүлээд байсан бөгөөд 1970 онд дотоодын их, дээд сургуулийг өдрийн ангиар 1329, орой, эчнээгээр 142 хүн төгссөн байна. Мөн онд гадаадын буюу социалист бусад орнуудын их дээд сургуульд төгсөгчдийн тоо 1958 оныхоос 4.6 дахин нэмэгдэж 354 болжээ (Бадрах, 1989: 87). Энэ үед манай улсын хүн ам нэлээд өсөж нэг саяыг даваад байсан юм.

БНМАУ-ын иргэд бүх төрлийн сургуульд үнэ төлбөргүй сурч боловсрох эрхээ эдлэхийн сацуу тусгай мэргэжлийн дунд сургууль, дээд сургуулийн оюутнууд улсаас цалинжиж байв. БНМАУ-ын дээд боловсролын систем нь шинжлэх ухааны мэдлэгтэй, хөдөлмөрийн болон үзэл суртал, ёс суртахууны хүмүүжилтэй нам, засгийн “кадр”, удирдагч, мэргэжилтнүүд бэлтгэх зорилготой байлаа.

Ховдын багшийн дээд сургууль болон Орос хэлний дээд сургуулийг оролцуулаад БНМАУ-д 8 их дээд сургууль байсан бол Монгол улс 1992 онд 39, 1994 онд 104 их, дээд сургуультай болсон юм. Дэлхийн II дайны дараа буюу 1950-1960-аад онд Япон улсын боловсролын систем ардчилал, шинэчлэлд тулгуурлан хурдацтай хөгжсөнөөр тус улсад 4

жилийн сургалттай 138 их дээд сургууль, 199 коллеж шинээр нэмэгдсэн байдаг (Туул, 2023). Манай анхны хувийн дээд сургуулиудыг Монгол бизнес, Хөгжмийн дээд сургууль, Монгол мэдлэг, Үндэсний биеийн тамирын дээд сургууль, Шонхор, Оточ Манарамба, Шихихутаг, Отгонтэнгэр гээд нэрлэж болохоор байсан бол 2005-2006 оны хичээлийн жилд хувийн сургуулийн тоо 125-д хүрч, үүний дээр 41 төрийн өмчийн, 6 гадаадын их сургуулийн салбар, нийт 180 дээд боловсролын сургалтын байгууллага Монголд үйл ажиллагаагаа явуулж байлаа. Энэ нь нэг талаас боловсролыг хүртээмжтэй болгож, нөгөө талаас эрдэм номыг эрхэмлэдэг иргэдийн зардлыг ачааллаж байв. Түүний дээр ихэнх шинээр

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судлаач нь Монгол улсын их, дээд сургуулийн төгсөгчдийн мэргэжлийн бүтэц БНМАУ-ын үеийнхээс ялгаатай гэж таамаглан социалист ба зах зээлийн үеийн холбогдох статистик мэдээллийг өөр хооронд нь болон түүхэн баримттай харьцуулан шинжлэв. Орчин үеийн суралцагчид нь өөрсдийн хүслээр юмуу ойр дотны хүмүүсийн зөвлөгөөний дагуу орлого олохуйц, боловсролд зарцуулсан зардлаа нөхөх мэргэжлээр сурсан байх магадлалтай. Энэхүү судалгаа нь Боловсролын Яам, Үндэсний статистикийн хорооны статистик мэдээ, тайлан эмхэтгэл болон холбогдох баримтад тулгуурласан ба мэдээллийн шинжилгээнд чанарын ба тоон аргыг хослон хэрэглэсэн болно.

байгуулагдсан хувийн сургуулиудын сургалтын чанар хэрэглэгчдийн хүлээлтэд хүрэхгүй байсан юм.

БНМАУ-ын төр, засаг социалист нийгмийн залуусыг шалгаруулж, дээд мэргэжилд төлөвлөгөөтэйгөөр, үнэ төлбөргүй сургаж, төгсөхөөр нь хүсэлтийг нь төдийлөн харгалзахгүй аль хэрэгцээг газарт томилдог байсан бол зах зээлийн нийгэмд иргэд мэргэжлээ өөрсдөө голдуу сонгон суралцаж, өөрсдөө ажлаа хайж олдог болсон юм. Энэхүү судалгаагаар БНМАУ ба Монгол улсын дээд боловсролын статистик мэдээг харьцуулж, энэ хугацаанд “Их, дээд сургуулийн төгсөгчдийн мэргэжлийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэдэг асуултад хариулахыг зорилоо.

III. СУДАЛГААНЫ ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Их, дээд сургуулийн төгсөгчдийн мэргэжлийн өөрчлөлт

Социализмын үе. Энэ үед их, дээд сургуулийг 87 мэргэжлээр ангилж товчоолдог байв. Эдгээр мэргэжлээр төгсөгчдийн тоог нийт төгсөгчдөд хувилахад хүний их эмч, монгол хэл, утга зохиол, инженер, орос хэл болон тоо физик, нябо, эдийн засагч гэсэн мэргэжлүүд эхний тавд эрэмбэлэгдсэн юм (хүснэгт 1). Энэ хүснэгтийн инженерийн бүлэгт барилгын, цахилгааны, дулааны, ойн, автын, сантехникийн, холбооны, ХАА-н машин механизмын, усны, геолог, гэрэл зураг хайгуулын инженер гэх мэт 21 төрлийн инженерийн мэргэжлийг багтаав. 1987 оны хүний их эмчийн ангилалд шинээр нэмэгдсэн хүүхдийн эмчийн тоог нэмж тооцсон бөгөөд эрүүл ахуйн эмчийг

оролцуулаагүй болно. Хүснэгтээс харахад, 1970-80-аад онд хүн амыг эрүүлжүүлэх, гэгээрүүлэх ажлыг чухалчилсаар байсан нь илт бөгөөд 1980-аад онд төрөл бүрийн инженерийн ба

үйлдвэрийн инженер-эдийн засагчдын тоо (1980 онд дангаараа 78 болж) өссөн нь улс ардын аж ахуйг, тэр дундаа аж үйлдвэрийг хөгжүүлэх 5 жилийн зорилттой уялдаж байлаа.

Мэргэжлийн нэр	1975	Эрэмбэ	1980	Эрэмбэ	1987	Эрэмбэ
Бүгд, тоогоор	1334		1984		2939	
Нийт хувь	100		100		100	
Үүнээс: Хүний их эмч	16.04	1	11.19	2	11.30	2
Монгол хэл, утга зохиол	11.02	2	5.95	3	5.07	4
Бүх төрлийн инженер	10.94	3	17.39	1	24.40	1
Орос хэл	7.87	5	5.54	4	4.56	5
Тоо физик	8.85	4	5.29	5		
Нябо эдийн засагч					7.69	3
Бусад	42.13		50.40		42.53	

Хүснэгт 1. 1970, 80-аад онд дээд сургуулийг өдрийн ангиар төгсөгчдийн тоо, зонхилох мэргэжлээр (%)
Эх үүсвэр: БНМАУ-ын ардын боловсролын хөгжилт. 1989, тал 88-89

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед “ханасан” зарим мэргэжлээр их дээд сургуульд оюутан элсүүлдэггүй, өнждөг байсан юм. Үүнд материалын технолог, математикч, ойн инженер-эдийн засагч, хөгжимчин, хятад хэлний гэх мэт мэргэжил багтаж байв. Зөвлөлтийн удирдагч, зөвлөхүүдтэй харилцах, үг хэлээ ололцох, дэлхийн ба Европын соёлтой танилцах, мэргэжих, боловсрох гүүр нь орос хэл байсны улмаас орос хэлний багш нарыг олноор нь бэлдэж байжээ.

1980-аад оны II хагаст жилд дунджаар 1000 орчим монголчууд гадаадын их, дээд сургуулийг дүүргэж байлаа. 10000 хүн амд ногдох суралцагчдын тоогоороо манай улс ЗХУ-аас доогуур, Европын социалист орнуудаас дээгүүр үзүүлэлттэй хэдий ч (хүснэгт 2) зарим мэргэжилтнүүдийнхээ, тухайлбал ЗХУ, Румын, Польш зэрэг улсын их дээд

сургуулиудад статистик, кибернетик, эконометрикс зэрэг мэргэжлээр бэлтгэсэн хүмүүсийнхээ мэдлэг, чадварыг дутуу ашиглаж байгаа нь 1980-аад оны дундуур Москвагийн Эдийн засаг-статистикийн Дээд сургуульд бичигч миний хамт суралцаж төгссөн болон бусад хүмүүсийн ажлын түүхээс харагддаг байв. “Монгол улсын үйлдвэржүүлэлтийн түүхээс дурсахуй” номонд зарим тохиолдолд гадаадын их дээд сургуульд ховор нарийн мэргэжлээр төгссөн хүмүүсийн мэдлэг чадвар ер ашиглагдаагүй тухай дурдсан байдаг (Ц. Гүрбадам, 2004). Энэ (underemployment) нь боловсролтой монголчууд, эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн орнуудаас хөгжлөөр хоцрох нэг шалтгаан байв. Гэсэн ч социализмын жилүүдэд манай улсын хүн ам бичиг үсэг тайлагдаж, соёл, шинжлэх ухааныг урагштай

хөгжүүлж, хүн амыг өсгөх, эрүүлжүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх зорилтыг боловсролын салбартай уялдуулан 5 жилээр төлөвлөж, хэрэгжүүлсэн. Энэ бол тухайн нийгмийн ололт байсан юм. Орчин үе. 2024-2025 оны хичээлийн жилд Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургуулийн тоо хориод жилийн өмнөхөөс 110 гаруйгаар буурсан байв. Одоо нийт 65 сургууль

байгаагийн 17 нь төрийн өмчийн, 45 нь хувийн өмчийн, 3 нь олон нийтийн/шашны сургалтын байгууллага юм. Эдгээр сургуульд 11403 багш, ажиллагчид ажиллаж, 150282 хүн суралцаж байгаа бөгөөд оюутнуудын 61.4 хувь нь эмэгтэй байлаа. Нийт оюутнуудын тал гаруй хувь нь төрийн өмчийн сургуульд, 94 орчим хувь нь Улаанбаатарт суралцаж байна.

Улс	1970	1975	1980	1985
Болгар	108	127	98	116
Унгар	78	102	93	93
Вьетнам	-	19	21.1	20.7
Ардчилсан Герман	84	81	78	79
Куба	41	91	232	251.6
Монгол	68	94	130	121
Польш	101	137	91	89
Румын	75	77	70	69
ЗХУ	188	190	185	181
Чехословак	91	104	109	109

Хүснэгт 2. Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн орнуудын дээд сургуульд суралцагчдын тоо (10000 хүн амд)

Эх үүсвэр: БНМАУ-ын ардын боловсролын хөгжилт. 1989, тал 90

Үзүүлэлт	2019-20	хувь	эрэмбэ	2023-24	хувь	эрэмбэ
Бүгд	28,045	100		27,555	100	
Боловсрол	5,513	19.7	2	4,229	15.3	3
Урлаг, хүмүүнлэг	1,741	6.2	5	1,759	6.4	5
Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	1,283	4.6		1,702	6.2	
Бизнес, удирдахуй, хууль, эрх зүй	9,462	33.7	1	8,816	32.0	1
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	745	2.7		522	1.9	
Мэдээлэл, харилцаа холбооны технологи	867	3.1		1,082	3.9	
Инженер, үйлдвэрлэл, барилга угсралт	4,306	15.4	3	3,118	11.3	4
Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг	397	1.4		271	1.0	
Эрүүл мэнд, нийгмийн халамж	3,276	11.7	4	4,779	17.3	2
Үйлчилгээ	455	1.6		1,277	4.6	

Хүснэгт 3. Дотоодын их, дээд сургууль, коллежийг төгсөгчид, мэргэжлийн чиглэлээр

Эх үүсвэр: YCX, 1212.mn

Боловсролын яам дотоодын их, дээд сургууль, коллежийг төгсөгчдийг мэргэжлээр нь 89, ерөнхийд нь 10 ангилж тайлан мэдээ гаргаж байна. Үүнээс 2019-20 ба 2023-24 оны хичээлийн жилд төгсөгчдийн мэдээг шинжиллээ (хүснэгт 3).

3 дугаар хүснэгтээс харахад, бизнес, удирдахуй, хууль эрх зүйгээр төгсөгчид нийт төгсөгчдийн 1/3 болж, тэр дундаа бизнес ба удирдахуй давамгайлж байгаа нь энэ үеийн дээд боловсролын онцлог байв. Түүнээс гадна социализмын үетэй харьцуулахад инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын мэргэжилтний эрэмбэ ухарч, мөн урлаг хүмүүнлэгийн мэргэжил тоо физикийг түрж, хамгийн их төгсөгчтэй таван мэргэжилд багтжээ. Бизнес, удирдахуй, хууль эрх зүйн мэргэжлээр төгсөгчдийн тоог инженер, үйлдвэрлэл, барилга угсралт ба хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлгээр төгсөгчдийн тоонд харьцуулахад 2020 онд 2:1, 2024 онд 3:1 орчим харьцаатай байсан юм. Өөрөөр хэлбэл хийдэг ганц мэргэжилтэнд зааварладаг, хууль эрхийг таниулж, зохицуулдаг, цалин мөнгийг нь тавьдаг, татдаг хоёроос гурван хүн ногдож байна.

Боловсролын Яамны албан мэдээгээр, 2024-25 оны хичээлийн жилд хөгжим тайз дэлгэцийн урлагт суралцахаар 303 оюутан элсжээ. Мөн дээд боловсролын сургалтын байгууллагад хэлний мэргэжлээр 647 хүн элссэн нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистикаар элсэгчдийн нийт тоонд (702) дөхөхөөр байв. Хэлний чиглэлээр элсэгчид гадаад хэлийг түлхүү

сонгожээ. Тус хичээлийн жилд мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлээр элсэгчдийн тоо 1410-д хүрсэн, тэр дундаа програм хангамж, хөгжүүлэлтийн мэргэжлээр элссэн 915 хүн байв. 2025 оны Боловсролын Яамны тэргүүлэх чиглэлд “Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ” гэж зааснаас эхний зорилт нь л дээд боловсролын хүрээнд хэрэгжих магадлалтай байна.

БНМАУ ба Монгол улсын боловсролын салбарын статистик өөрчлөлтийг баримтын энгийн судалгааны үр дүнтэй харьцуулахад дараах зураглал гарсан юм. Монгол Ардын Намын 100 жилийн түүхийг хураангуйлсан 100 картыг шинжлэхэд нам байгуулагдсанаас 1990 он хүртэлх картад анагаах, соёл урлаг, боловсрол, газар тариалан, мал аж ахуй, аж үйлдвэр гэх мэт бүх салбарт гарсан ололт, бүтээн байгуулалтын тухай зураг байв. 1940 онд манай улсын нийгмийн нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн эзлэх хувийн жин 12.7 хувь байсан бол 1990 он гэхэд 49 хувь болж өсжээ (УСГ, 1991: 32-33). Ийм амжилтад гадаад дотоодын сургуульд бэлтгэгдсэн мэргэжилтнүүд, удирдагчид, жирийн хөдөлмөрчдийн хөлс хүч шингэснийг зургуудад харуулжээ.

Энгийнээр жишээлж хэлбэл, монгол хонины ахар ноосыг нарийвтар болгож, ноосны гарц, чанарыг дээшлүүлэхийн тулд эрдэмтэд мал аж

ахуйн мэргэжилтнүүдтэй хамтран туршилт судалгаа явуулж, малчид сайжруулсан үүлдрийн мал өсгөн үржүүлж, тэднээс бэлтгэсэн түүхий эдийг үйлдвэрт боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүгээр эх орны болон гадаадын хэрэглэгчдийн хэрэгцээг хангаж, өөрт хэрэгцээтэйгээ импортлож, үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагааг тээвэр, уул уурхай, түлш эрчим хүч, хүнсний гэх мэт бусад салбарууд хангаж, эдгээр үйл

ажиллагааг удирдлагууд зангидаж байв. Харамсалтай нь энэ том хэлхээг ба социалист үйлдвэрүүдийг гэнэт тасчин хувьчилж, 1990 онд шинээр суурилуулсан 5 орны машин техникийг хүртэл төмрийн хогонд шилжүүлснээр олон жил, олон түмний хөдөлмөрөөр боссон аж үйлдвэрийн салбар нурж, ажилгүйдэл манай улсад нүүрлэсэн юм (Нарантуяа, 2020: 128-129).

1990 оноос өмнө



1990-2021 оны 32 түүхэн картыг үзвэл, нэг нь нийслэлийн нэг хэсгийн зураг, 31 нь “удирдахуй”-тай холбоотой түүх буюу хурал, цуглаан, уулзалт, ярианы зургууд байв.

1990 оноос хойш



Эх үүсвэр: МАН-ын 100 жилийн түүхийг хураангуйлсан карт. 2021

Товчдоо энэ 31 зурагт их дээд боловсролтой мэргэжилтнүүд ба удирдагчид 30 гаруй жил хуралдаж ярьсныг, төрийн ба хувьчилсан үйлдвэрийн үйл ажиллагааг ил биш далд явуулдаг “бизнес-удирдахуй” тусгагджээ. 2010 оны хүн амын тооллогын үр дүнг харахад, менежерүүдийн цалин уул уурхайн салбарт ажилладаг хүмүүсийн дараа дээрээсээ хоёрт эрэмбэлэгдэж, бусад эрчүүдээс эрт гэрлэж байсан юм. Энэ нь бизнес, удирдахуйн мэргэжлээр төгсөгчдийн тоог нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байж магадгүй.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны сургуулийн магистрантур, докторантур

суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу төгссөнөөс хойш 5-аас доошгүй жил ажиллах нөхцөлтэйгөөр Сургалтын төрийн сангийн зээл олгодог болсноор 2000-2005 онд нийт 645 хүн өндөр хөгжилтэй оронд суралцсан нь ардчиллын жилүүдэд гарсан эерэг өөрчлөлт байсан юм. Эдгээр хүмүүсийн 229 нь АНУ-д, 106 нь Японд, 80 нь ОХУ-д, 66 нь Англид суралцсан байна (БСШУЯ, 2005: 71).

2024-25 оны хичээлийн жилд Боловсролын зээлийн сангийн тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжид хамрагдсан гадаадад суралцагчид 1061 байв. Социализмын үед Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн орнуудад, Европт голдуу суралцдаг байсан бол өнөөдөр эдгээр орнуудаас гадна АНУ, Англи, Австрали, Канад, Япон, Солонгос, Хятадад суралцагчид олширчээ. Мөн хичээлийн жилд Монгол

улсын их дээд сургууль коллежид 4722 оюутан суралцаж байгаагаас 4053 нь БНХАУ, 473 нь ОХУ-ын оюутнууд байлаа.

IV. ДҮГНЭЛТ

1942 онд МУИС байгуулагдаж, 1946 онд анхны төгсөлтөө хийж, 35 оюутан дээд боловсролын диплом гардан авч байсан бол эдүгээ Монгол улсад төрийн болон бусад өмчийн 65 их, дээд сургууль, коллежид 11403 багш ажиллагчид ажиллаж, 150282 оюутан суралцаж, жил бүр гучаад мянган хүн төгсдөг болжээ. Социализмын үед хүний их эмч, монгол хэл, утга зохиол, инженер, орос хэл болон тоо физик, нябо, эдийн засагч гэсэн мэргэжлүүдээр голлон төгсөж байсан бол орчин үед бизнес, удирдахуй, хууль эрх зүйгээр төгсөгчид нийт төгсөгчдийн 1/3-ийг эзлэх болсон байна. Үүнээс гадна урлаг хүмүүнлэгийн мэргэжлээр төгсөгчдийн тоо нэмэгдэж эхний тавд эрэмбэлэгдэх болжээ.

1990 оноос өмнө манай улсын дээд боловсролын систем нь хүн амыг эрүүлжүүлэх, гэгээрүүлэхийн зэрэгцээ социалист нийгмийн мэргэжилтэн, удирдагчид бэлтгэж, ХАА, үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлтэй байсан бол орчин үеийн оюутнууд бизнес ба удирдахуйгаар суралцах сонирхолтой болжээ. Мөн програм хангамж,

хөгжүүлэлт болон хэлний мэргэжлээр суралцагчдын тоо өссөн байна. 1990 оноос хойш монголчууд Боловсролын зээлийн сангийн тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжид хамрагдан барууны өндөр хөгжилтэй орнуудад суралцах болсон нь ардчиллын жилүүдэд гарсан нэг том өөрчлөлт байлаа.

Ашигласан материал

- Бадрах, Ц. Г. (1989). *БНМАУ-ын Ардын боловсролын хөгжилт*. УБ: Улсын хэвлэлийн газар.
- Боловсролын Яам (2025). *Боловсролын салбарын статистикийн мэдээлэл. 2024-2025*. УБ
- БСШУЯ. (2001). *Монгол улсын боловсролын салбарын үүсэл хөгжил*. УБ: Улсын хэвлэлийн газар
- БСШУЯ. (2005). *Боловсрол, соёл, шинжлэх ухаан. 2001-2005*. УБ: ТЗҮААГ хэвлэх үйлдвэр.
- Гурбадам, Ц. (2004). *Монгол улсын үйлдвэржүүлэлтийн түүхээс дурсахуй*. УБ: Урлах эрдэм Ленин, В. (1975).

- Зохиолууд. Боть 27. УБ: Улсын хэвлэлийн газар.
- МАН (2021). МАН-ын 100 жилийн түүхийг хураангуйлсан карт. 1921-2021. УБ
- Нарантуяа, Д. (2020). *Монголын нийгэм ба шүтээн*. УБ: МУИС Пресс.
- Туул, С., Д. Оюунцэцэг, Л. Энхжин (2023) *Олон улс судлал-2022 номын "Японы дээд боловсролын онцлог ба зарим асуудал"*.
- УСГ. (1991). *БНМАУ-ын улс ардын аж ахуй 70 жилд. 1921-1991*. УБ.
- ШУА. Түүхийн хүрээлэн (1986). *БНМАУ-ын соёлын түүх*. УБ: Улсын хэвлэлийн газар.